



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 553

Улаанбаатар хот


“Волтам” ХХК-ийн үнэт цаасыг нийтэд санал  
болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны  
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 127 дугаар тогтоолоор бүртгэсэн “Волтам” ХХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 185,578,456 (нэг зуун наян таван сая таван зуун далан найман мянга дөрвөн зуун тавин зургаа) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн), төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва), арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай)-д тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН